

ТАНИЛЦУУЛГА

*Тэтгэвэр авах дундаж хугацааны
илэрхийлэл (“К”)-ийн тооцоолол хийсэн тухай*

2021.11.20

Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл 2014, 2017, 2019 онуудад баталж байсан.

Хүснэгт 1

Хүйс	Он						
	2015	2016	2017	2018	2019	2020	2021
Эмэгтэй	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар	22 жил 6 сар
Эрэгтэй	-	-	-	-	-	15 жил 6 сар	15 жил 6 сар

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 180 сар ба түүнээс дээш хугацаагаар төлсөн 55 нас хүрсэн эмэгтэй, 60 нас хүрсэн эрэгтэй даатгуулагчид өндөр насны тэтгэвэрт тогтоолгоход баримтлах тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийг Үндэсний статистикийн хорооны 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 01/957 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэдийн мэдээллийг ашиглан судалгаа хийсэн.

Үндэсний статистикийн хорооноос 2022-2025 онд 55 нас хүрэх эмэгтэй хүн 27.8 жил, 60 нас хүрэх эрэгтэй хүн 17.7 жил үргэлжлэн амьдрах тооцооллыг хийж ирүүлсэн.

НАС БАРСАН ХҮНИЙ ТОО, хүйс, насны бүлгээр¹

Хүснэгт 2

Хүйс	Насны бүлэг	Он										
		2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эрэгтэй	60-64	840	860	785	833	905	886	904	1028	1123	1215	1169
Эрэгтэй	65-69	827	798	728	716	697	740	809	742	859	891	867
Эрэгтэй	70+	2403	2411	2197	2349	1962	2390	2347	2356	2377	2366	2328
Нийт		4070	4069	3710	3898	3564	4016	4060	4126	4359	4472	4364
Эмэгтэй	55-59	499	478	449	496	534	613	569	577	618	630	555
Эмэгтэй	60-64	521	505	499	535	503	568	526	565	616	621	584
Эмэгтэй	65-69	610	588	539	517	515	554	641	604	579	583	616
Эмэгтэй	70+	2928	2796	2661	2799	2525	2927	2906	2819	3003	2917	2809
Нийт		4558	4367	4148	4347	4077	4662	4642	4565	4816	4751	4564

Нийгмийн даатгалын сангаас 2006-аас 2020 онд өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэдийн мэдээллийг ашиглан тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийллийн судалгааг хийсэн.

¹ Үндэсний статистикийн хорооны 1212.mn цахим хуудаснаас авсан тоон мэдээлэл

Судалгаанаас харахад 2006-аас 2020 онд 60 нас хүрсэн эрэгтэй даатгуулагчид дунджаар 13 жил 4 сар, 55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагчид дунджаар 21 жил 2 сар тэтгэвэр авсан байна.

ТЭТГЭВЭР АВСАН ДУНДАЖ ХУГАЦААНЫ ИЛЭРХИЙЛЭЛ жил (ж), сар (с), хүйс²

Хүснэгт 3

Хүйс	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020
Эр	13 ж 2 с	13 ж 3 с	13 ж 2 с	13 ж 3 с	13 ж 6 с	13 ж 7 с	13 ж 6 с	13 ж 11 с	13 ж 8 с	13 ж 5 с	13 ж 3 с	13 ж 4 с	13 ж 5 с
Эм	20 ж 9 с	21 ж 10 с	21 ж 8 с	21 ж 3 с	21 ж 4 с	21 ж 2 с	20 ж 10 с	20 ж 5 с	20 ж 7 с	19 ж 10 с	20 ж 2 с	19 ж 6 с	19 ж 7 с

Мөн дээрх түүвэр судалгааны хазайлт эрэгтэй 5 сар, эмэгтэй 9 сар байна.

Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн санал, нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэдийн судалгааг харьцуулан дунджаар авч үзэхэд тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”) нь 2022, 2023, 2024 онд эрэгтэй даатгуулагчид 15 жил 7 сар байхаар байна.

Эрэгтэй даатгуулагчдын хувьд Үндэсний статистикийн хорооны 2019 онд ирүүлсэн санал, 2021 онд ирүүлсэн саналтай адилхан байсан.

Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн саналд 55 нас хүрсэн эмэгтэйн үргэлжлэн амьдрах хугацаа 27.8 жил буюу 2019 оноос 2.5 жилээр насжилт их байгаа боловч нийгмийн даатгал төлж байгаад 55 насандаа өндөр насны тэтгэвэрт гарч байгаа иргэдийн хувьд үргэлжлэн амьдрах хугацаа буюу тэтгэвэр авах хугацаа³ бууралттай харагдаж байна.

Дээрх 2 судалгаанаас эмэгтэй даатгуулагчидын тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-г 2022, 2023, 2024 онд хамгийн их урт хугацаанд тэтгэвэр авсан дундаж хугацаа буюу 2009 оны 21 жил 10 сар дээр тухайн түүврийн далайц болох 9 сарыг нэмэгдүүлэн 22 жил 7 сар байхаар тооцооллоо.

Дээрх тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”)-г ашиглан, 2020 оны жилийн эцсийн байдлаар 55 настай эмэгтэй, 60 настай эрэгтэй албан журмын даатгал төлөгчдын тэтгэвэр тогтоолтыг хүснэгтээр харууллаа.

№	Хүйс	Нас	2020 оны жилийн эцсийн нэрийн дансны дундаж үлдэгдэл	Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл (“К”) ⁴	Бодогдсон тэтгэвэр
1	Эмэгтэй	55	72,994,431.1	22.58	269,352.1
2	Эрэгтэй	60	66,049,009.3	15.58	353,203.3

---oOo---

²Нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авч байгаад нас барсан иргэдийн мэдээллийн сангаас

³Хүснэгт 2

⁴ Сарыг жилрүү шилжүүлэхдээ ”Сар/12” томъёогоор бодоход 7 сар нь 0.58333 болж байна.